



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Банк бус санхүүгийн байгууллагын газар

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668, Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт.....	7
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт ..	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
Статистик үзүүлэлтүүд	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид, ажилчид	9
Тархалт	10
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	11
Мөнгөн хөрөнгө.....	12
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	12
Факторингийн тооцооны авлага.....	13
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө.....	13
Зээл.....	13
Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	16
Бусад хөрөнгө.....	17
Эргэлтийн бус хөрөнгө	17
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	18
Санхүүгийн эх үүсвэр	19
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	19
Бусад эх үүсвэр	19
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	20
Төслийн зээлийн санхүүжилт.....	21
Бусад өр төлбөр.....	22
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	22
Бусад өмч, сангууд	23
Хуримтлагдсан ашиг	23
Хоёрдогч өглөг.....	24
Ашигт ажиллагаа	25
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	27
Дүгнэлт	28

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоон мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл.....	9
Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл	9
Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	10
Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	11
Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	15
Хүснэгт 18 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 19 Уламжлалт болон финтек зээлийн тоо мэдээ	16
Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	16
Хүснэгт 21 Зээл олгож буй аппликэйшнүүд.....	16
Хүснэгт 22 Мост мони-д холбогдсон ББСБ-ууд.....	16
Хүснэгт 23 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	17
Хүснэгт 24 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	17
Хүснэгт 25 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 26 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/.....	19
Хүснэгт 27 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	19
Хүснэгт 28 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 29 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/.....	20
Хүснэгт 30 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	21
Хүснэгт 31 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	22
Хүснэгт 32 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 33 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 34 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 35 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/	23
Хүснэгт 36 Хоёрдогч өглөгийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/	24
Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/	25
Хүснэгт 38 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 39 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	27

Зургийн жагсаалт

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	11
Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/.....	14
Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/.....	14
Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	15
Зураг 6 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	18
Зураг 7 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	19
Зураг 8 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/	20
Зураг 9 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	20

Зураг 10 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/22

Зураг 11 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....25

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Ерөнхий төлөв байдал

2021 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 534 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 2 ББСБ буюу 0.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 83 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоон мэдээлэл

	IV улирал				
	2017	2018	2019	2020	2021
Шинээр олгосон	31	15	14	14	14
Хүчингүй	15	10	15	20	12
Түдгэлзүүлсэн	23	22	13	34	29
Сэргээсэн	8	7	9	9	8
Нийт ББСБ	534	539	538	532	534
Үүнээс: ХОН	70	73	75	77	83
Үүнээс: ГХО	27	29	27	30	28
Салбар	164	230	250	295	331
Төлөөлөгч	4	5	7	9	8

Тайлант хугацаанд нийт 14 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 12 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 29 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 8 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2021 оны жилийн эцсийн байдлаар 28 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2020.IV	2021.IV	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	2006.9	2,709.9	35.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	5.5%	6.6%	1.1%
Нийт өөрийн хөрөнгө	1450.7	1,799.1	24.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	47.4%	52.5%	5.1%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1017.7	1,114.1	9.5%
Банкны салбартай харьцуулахад хувиар	132.2%	77.7%	-54.5%
Нийт зээл	1327.0	2,012.2	51.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	7.5%	9.5%	2.0%
Нийт орлого	408.8	521.3	27.5%
Нийт зарлага	254.0	311.3	22.6%
Цэвэр ашиг	154.8	210.0	35.7%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 703.1 тэрбум төгрөгөөр буюу 35.0 хувиар өсөж 2.7 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын 6.6%-тай тэнцэж байна. Активын өсөлтийн 97.5 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байгаа бол пассивын өсөлтийн 49.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт, 50.4 хувийг өр төлбөрийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 112.5 хувиар буюу 27.5 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 22.6 хувиар буюу 57.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 35.7 хувиар буюу 55.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2020.I V	2021.I V	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		532	534	2	0.4%
1	Зээл	494	496	2	0.4%
Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг		335	326	(9)	-2.7%
2	Факторинг	34	40	6	17.6%
3	Төлбөрийн баталгаа гаргах	21	24	3	14.3%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	5	-	0.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	34	36	2	5.9%
6	Гадаад валютын арилжаа	147	146	(1)	-0.7%
Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг		38	38	-	0.0%
7	Итгэлцэл	43	49	6	14.0%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	11	20	9	81.8%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	37	40	3	8.1%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 534 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 92.9% нь буюу 496 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 61.0% нь буюу 326 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 146 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 27.3 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 38 ББСБ нийт ББСБ-уудын 7.1 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн

үеэс 2.7 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 81.8 хувиар, факторингийн үйлчилгээ 17.6 хувиар, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ 14.3 хувиар, итгэлцлийн үйлчилгээний 14.0 хувиар тус тус өссөн байна.

2021 оны жилийн эцсийн тайлан мэдээний ирц 96.8% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 534 ББСБ-аас 517 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 15 ББСБ өмнөх үеийн, 2 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. Өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан 15 ББСБ-аас 8 ББСБ-ын үйл ажиллагааг 3 сарын хугацаанд түдгэлзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах дүрэм журмуудыг шинэчлэн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээ.

- “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [65 дугаар тогтоолоор](#) батлуулсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан. Үүний дараагаар дээрх тогтоолыг сунгаж, 2021 оны 9 дүгээр сарын 22-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [385 дугаар тогтоолоор](#) баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авсан.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 441 дүгээр тогтоол /Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай/-ын хавсралтад өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [66 дугаар тогтоолоор](#) батлуулсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 3 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан.

- “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж, 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [165 дугаар тогтоолоор](#) баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 5237 дугаарт бүртгэсэн.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "2021 оны 12 дугаар сарын 31-ний" гэснийг "2022 оны 12 дугаар сарын 31-ний" гэж өөрчлөн хууль хэрэгжих хугацаа сунгагдсанаар энэхүү журмын үйлчлэх хугацаа мөн адил хугацаанд сунгагдсан.

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед банк бус санхүүгийн байгууллагуудад хэрэгжүүлэх арга хэмжээний тухай (2021 оныг дуустал зээлийн гэрээнд 2 ба түүнээс дээш удаа өөрчлөлт оруулсан тохиолдолд ангилал бууруулан бүртгэх журмын үйлчлэлийг түр зогсоох мөн 60 хоног хүртэлх хугацаанд хэвийн ангилалд ангилан бүртгэнэ.) тогтоолыг боловсруулж, 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [262 дугаар тогтоолоор](#) батлуулсан.

Дээрх тогтоолын хэрэгжих хугацаа 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дууссан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 998 дугаар тогтоолоор баталсан “[Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам](#)”-ыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллана.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2021 оны жилийн эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 91.7% буюу 488 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 456 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн

талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 496 ББСБ-ын 85.1% буюу 422 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.”

гэж заасны дагуу нэр бүхий 167 ББСБ, 16,824 удаагийн тохиолдлоор, 1.5 их наяд төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 7 ББСБ, 32 удаагийн тохиолдлоор, 1.3 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 522 ББСБ-аас 1,318.9 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 96.6% буюу 504 ББСБ 1,271.2 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2021 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 21,793 хувьцаа эзэмшигчдийн 534 ББСБ, 331 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,976 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.8 сая харилцагч, 1.7 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,820,624	3,652,202	381,081	4,439,543	35,313	4,798,436	22,188	1,268,619	94,247
Үүнээс: Эмэгтэй	2,257,827	1,999,254	196,486	2,061,341	18,492	2,244,647	13,180	695,037	48,681
Эрэгтэй	2,556,710	1,652,262	178,953	2,377,757	14,778	2,547,761	8,949	573,201	45,338
Хуулийн этгээд	6,087	686	5,642	445	2,043	6,028	59	381	228
Итгэмжлэгчдийн тоо	5,093	5,092	2,584	2,509	-	5,089	4	285	254
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,274	1,162	330	944	-	1,271	3	761	191
Зээлдэгчдийн тоо	1,678,139	605,703	299,645	1,378,494	-	1,656,659	21,480	280,104	94,247
Үүнээс: Иргэн	1,676,528	605,318	298,217	1,378,311	-	1,655,097	21,431	279,979	94,019
Хуулийн этгээд	1,611	385	1,428	183	-	1,562	49	125	228
Хэвийн	1,578,254	522,285	267,402	1,310,852	-	1,558,702	19,552	220,801	78,877
Анхаарал хандуулах	36,372	30,850	14,269	22,103	-	35,544	828	21,483	8,030
Чанаргүй:	63,513	52,568	17,974	45,539	-	62,413	1,100	37,820	7,340
-Хэвийн бус	17,283	14,408	5,289	11,994	-	17,060	223	9,571	1,911
-Эргэлзээтэй	15,556	13,618	4,190	11,366	-	15,421	135	10,621	1,685
-Муу	30,674	24,542	8,495	22,179	-	29,932	742	17,628	3,744
Зээлдэгчдийн насжилт	1,676,528	605,318	298,217	1,378,311	-	1,655,097	21,431	279,979	94,019
18-35 насны	553,600	335,976	151,481	402,119	-	545,392	8,208	163,559	57,655
36-45 насны	967,564	161,975	91,698	875,866	-	960,505	7,059	73,156	23,114
46-55 насны	117,392	78,800	41,520	75,872	-	113,308	4,084	32,924	10,619
55-аас дээш	37,972	28,567	13,518	24,454	-	35,892	2,080	10,340	2,631
Зээлдэгчдийн боловсрол	1,676,528	605,318	298,217	1,378,311	-	1,655,097	21,431	279,979	94,019
-Дээд	1,289,468	333,909	177,631	1,111,837	-	1,278,415	11,053	165,991	59,050
-Тусгай дунд	107,866	56,414	44,487	63,379	-	102,879	4,987	17,492	14,966
-Бүрэн дунд	221,168	167,876	60,240	160,928	-	217,962	3,206	82,575	16,191
-Дунд	45,516	35,862	11,045	34,471	-	43,870	1,646	10,027	3,604
-Бага	12,510	11,257	4,814	7,696	-	11,971	539	3,894	208

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын давхардсан тоогоор өмнөх оны мөн үеэс 69.5 хувиар өсөж 4.8 саяд, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өсөж 1.7 саяд хүрлээ. Зээлдэгчдийн тоо огцом өссөн нь аппликэйшн ашиглан бага дүнтэй богино хугацаатай зээл олгодог ББСБ-ууд нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2017-IV	2018-IV	2019-IV	2020-IV	2021-IV	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,039	4,875	7,712	8,869	21,793	12,924	145.7%
Ажилчдын тоо	2,473	2,784	2,962	3,437	3,976	539	15.7%
Харилцагчдын тоо	1,471,099	1,601,749	2,854,530	2,844,782	4,820,624	1,975,842	69.5%
Зээлдэгчдийн тоо	107,442	234,080	419,854	788,058	1,678,139	890,081	112.9%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	3.4%	3.3%	3.0%	2.8%	2.7%	-0.5 пункт	

Хувьцаа эзэмшигчид, ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсөж 21,793-д хүрсэн байна. Нийт өсөлтийн 89.5 хувийг тус ББСБ-ын харилцагчдын өсөлт бүрдүүлж байгаа ба өмнөх оны мөн үеэс 6.4 дахин огцом өсжээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 19,134 буюу 87.8% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 2,659 буюу 12.2% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	21,793	20,881	2,659	19,134	62	21,599	194	20,755	1,743
Нийт ажилтнуудын тоо	3,976	1,638	2,725	1,251	91	3,759	217	291	404
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	2,309	899	1,638	671	51	2,158	151	170	237

Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,743 буюу 8.0% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 194 буюу 0.9% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хөдөө орон нутгийн 83 ББСБ 6 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин тодорхойгүйн улмаас одоогоор тухайн төрлийн үйлчилгээ

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	534	49	506	28	38	451	83	4	530	27
1 Зээл	496	49	468	28	-	416	80	4	492	27
2 Факторингийн үйлчилгээ	40	17	28	12	-	40	-	2	38	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	24	9	20	4	-	23	1	1	23	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	2	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	36	13	24	12	-	36	-	2	34	1
6 Гадаад валютын арилжаа	146	26	133	13	38	136	10	3	143	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	49	49	35	14	-	48	1	4	45	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	20	12	15	5	-	19	1	2	18	3
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	40	19	32	8	-	38	2	4	36	5

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 84.5% буюу 451 ББСБ, салбаруудын 70.4% буюу 233 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 15.5% буюу 83 ББСБ, салбаруудын 29.6% буюу 98 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар 83 ББСБ-ын 331 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 63.7 хувийг 14 ББСБ-ын 211 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	451	233	684	100.0%
Сүхбаатар дүүрэг	155	40	195	28.5%
Чингэлтэй дүүрэг	127	25	152	22.2%
Баянгол дүүрэг	73	38	111	16.2%
Баянзүрх дүүрэг	51	59	110	16.1%
Хан-Уул дүүрэг	34	32	66	9.6%
Налайх дүүрэг	-	33	33	4.8%
Сонгинохайрхан дүүрэг	10	2	12	1.8%
Багануур дүүрэг	1	4	5	0.7%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар

дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн	Салбар	Нийт	Хувь
	83	98	181	100%
Архангай аймаг	1	2	3	1.7%
Баян-Өлгий аймаг	4	3	7	3.9%
Баянхонгор аймаг	3	5	8	4.4%
Булган аймаг	2	-	2	1.1%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.2%
Дархан-Уул аймаг	7	11	18	9.9%
Дорноговь аймаг	2	6	8	4.4%
Дорнод аймаг	5	8	13	7.2%
Дундговь аймаг	1	3	4	2.2%
Завхан аймаг	2	1	3	1.7%
Орхон аймаг	7	13	20	11.0%
Өвөрхангай аймаг	9	6	15	8.3%
Өмнөговь аймаг	2	10	12	6.6%
Сүхбаатар аймаг	5	3	8	4.4%
Сэлэнгэ аймаг	5	6	11	6.1%
Төв аймаг	15	3	18	9.9%
Увс аймаг	3	4	7	3.9%
Ховд аймаг	1	3	4	2.2%
Хөвсгөл аймаг	3	5	8	4.4%
Хэнтий аймаг	3	4	7	3.9%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2021 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2.7 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.0 хувиар буюу 703.1 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 97.5 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2020.IV дүн	Нийт дүнд эзлэх хувь	2021.IV дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,927,819.7	96.1%	2,616,456.3	96.5%	688,636.7	35.7%
Мөнгөн хөрөнгө	491,462.7	24.5%	429,712.7	15.9%	-61,750.0	-12.6%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	11,939.3	0.6%	22,588.6	0.8%	10,649.3	89.2%
Зээл (цэврээр)	1,222,582.9	60.9%	1,897,466.7	70.0%	674,883.8	55.2%
Нийт зээл	1,327,028.9	66.1%	2,012,173.7	74.3%	685,144.8	51.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	104,445.9	5.2%	114,707.0	4.2%	10,261.0	9.8%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	3,030.1	0.2%	9,869.0	0.4%	6,839.0	225.7%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	15,048.6	0.7%	13,617.0	0.5%	-1,431.6	-9.5%
Бусад хөрөнгө	175,207.5	8.7%	243,124.1	9.0%	67,916.6	38.8%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн авлага	8,548.5	-	78.1	0.0%	-8,470.4	-
Эргэлтийн бус хөрөнгө	79,071.7	3.9%	93,493.3	3.5%	14,421.5	18.2%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	101,213.7	5.0%	119,460.9	4.4%	18,247.1	18.0%
(Хуримтлагдсан элэгдэл)	-22,142.0	-1.1%	-25,967.6	-1.0%	-3,825.6	17.3%
Нийт хөрөнгийн дүн	2,006,891.4	100.0%	2,709,949.6	100.0%	703,058.2	35.0%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2017 оны мөн үед 969.2 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.8 дахин өсөж 2.7 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 2.3 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 1 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 84.1% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 218 ББСБ, 8.0% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 99 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 7.9 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 217 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,869.6	93	69.0%	17.4%	7.3	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	410.4	125	15.1%	23.4%	6.1	2	4.7	1	-	-
1.9-2.5 тэрбум	215.8	99	8.0%	18.5%	-	-	2.2	1	-	-
1.4-1.9 тэрбум	152.5	94	5.6%	17.6%	3.3	2	6.3	4	1.9	1
0.6-1.4 тэрбум	39.1	36	1.4%	6.7%	4.4	5	9.0	10	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	22.6	87	0.8%	16.3%	1.2	4	12.5	50	8.9	33
НИЙТ	2,709.9	534	100.0%	100.0%	22.3	14	34.6	66	14.6	38

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн 28.2% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 47.0% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 21.5% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	429.7	117.5	332.1	97.6	14.1	416.9	12.8	29.5	47.1
Бэлэн мөнгө	121.1	5.1	117.9	3.1	13.1	114.1	7.0	0.0	2.9
Харилцах	202.0	72.1	142.6	59.4	0.6	197.2	4.8	24.9	31.4
Хадгаламж	106.6	40.3	71.5	35.1	0.4	105.6	1.1	4.6	12.8

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 35.5%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 3.2%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 92.7% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 2 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 89.2% буюу 10.6 тэрбум төгрөгөөр өсөж, 2021 оны жилийн эцсийн байдлаар 27 ББСБ 22.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 86.3% буюу 19.5 тэрбум төгрөгийг 18 ББСБ-ын арилжааны үнэт цаас, 14.1% буюу 3.2 тэрбум төгрөгийг 11 ББСБ-ын хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 68.1% буюу 15.4 тэрбум төгрөг нь хувьцаа, 30.9% буюу 7.0 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 1.4% буюу 320.3 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна. Хөдөө орон нутгийн 1 ББСБ 1.0 сая төгрөгийн засгийн газрын үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	22,588.6	20,711.0	10,453.2	12,135.5	1.0	21,836.9	751.7	13,826.7	6,090.0
Хувьцаа	15,376.0	13,608.6	8,543.0	6,833.0	1.0	14,625.3	750.7	10,808.1	5,990.9
Өрийн бичиг	6,986.0	6,886.8	1,899.2	5,086.8	-	6,986.0	-	2,708.4	99.2
Бусад	320.3	310.3	10.0	310.3	-	320.3	-	310.3	-
Засгийн газар	1.0		1.0				1.0		
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	3,194.7	2,554.6	941.1	2,253.6	-	3,194.7	-	599.3	-
Арилжааны үнэт цаас	19,488.6	18,251.1	9,512.1	9,976.5	1.0	18,736.8	751.7	13,227.5	6,090.0

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 20 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 27 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна.

Факторингийн тооцооны авлага

Факторингийн тооцооны авлага өмнөх оны мөн үеэс 3.3 дахин буюу 6.8 тэрбум төгрөгөөр өсөж 9.9 тэрбум төгрөгт хүрчээ. Факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэн хэдий ч 2021 оны жилийн эцсийн байдлаар 5 ББСБ 906.9 сая төгрөгийн анхаарал хандуулах болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 517.0 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 12 ББСБ нийт 9.9 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ.

Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 40 ББСБ-уудын 28 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2020.IV		2021.IV		Өөрчлөлт	
	Нийт дүн 3,087.9	Эзлэх хувь 100.0%	Нийт дүн 10,386.1	Эзлэх хувь 100.0%	Дүн	Хувь
Хэвийн	2,716.8	88.0%	9,479.2	91.3%	6,762.3	248.9%
Анхаарал хандуулах	304.8	9.9%	193.7	1.9%	(111.0)	-36.4%
Чанаргүй	66.3	2.1%	713.2	6.9%	646.9	975.3%
Хэвийн бус	23.8	0.8%	109.0	1.0%	85.1	357.2%
Эргэлзээтэй	11.6	0.4%	248.2	2.4%	236.6	2031.2%
Муу	30.8	1.0%	356.0	3.4%	325.2	1054.2%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	57.9	1.9%	517.0	5.0%	459.2	793.5%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөг буюу 9.5 хувиар буурч 13.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	13,617.0	4,564.0	11,942.5	1,674.5	13,035.5	581.5	783.6	12,833.4	2,411.0
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	15,411.1	4,988.8	13,772.1	1,638.9	15,253.1	158.0	1,579.1	13,832.0	2,908.7
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	4,977.4	1,660.2	4,676.2	301.3	4,977.4	-	795.5	4,181.9	990.4
Өмчлөх бусад хөрөнгө	3,183.4	1,235.3	2,846.6	336.8	2,759.9	423.5	-	3,183.4	492.6

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 51.6% буюу 685.1 тэрбум төгрөгөөр өсөж 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.0 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 114.7 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1.9 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/


	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,897.5	971.2	1,263.3	634.2	1,861.0	36.5	239.7	1,657.7	275.1
Нийт зээл	2,012.2	1,019.6	1,357.0	655.1	1,970.7	41.5	247.5	1,764.7	285.8
Хэвийн	1,821.9	942.1	1,203.8	618.2	1,786.8	35.2	235.8	1,586.1	269.0
Анхаарал хандуулах	50.0	19.9	37.5	12.5	49.2	0.8	2.6	47.4	3.0
Чанаргүй:	140.2	57.5	115.8	24.4	134.7	5.5	9.0	131.2	13.8
-Хэвийн бус	27.0	9.9	20.8	6.3	26.6	0.4	3.4	23.6	2.8
-Эргэлзээтэй	21.1	8.3	17.9	3.2	20.7	0.4	2.0	19.1	2.9
-Муу	92.0	39.4	77.1	15.0	87.3	4.7	3.6	88.4	8.2
(Зээлийн эрсдэлийн сан)	114.7	48.4	93.8	20.9	109.7	5.0	7.7	107.0	10.7
Нийт зээл (төгрөгийн)	1,947.4	968.3	1,306.9	640.6	1,906.3	41.1	219.0	1,728.5	252.5
Нийт зээл (валютын)	64.7	51.2	50.2	14.6	64.4	0.4	28.5	36.2	33.3
Зээлдэгчдийн тоо	1,678,139	605,703	299,645	1,378,494	1,656,659	21,480	280,104	1,398,035	94,247
- Иргэн	1,678,139	605,703	299,645	1,378,494	1,656,659	21,480	280,104	94,247	1,570,322
- Хуулийн этгээд	1,611	385	1,428	183	1,562	49	125	228	701

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/

Тайлант улиралд ББСБ-ууд 3.0 их наяд төгрөгийн зээлийг 2.7 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 2.3 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2021 оны жилийн


эцсийн байдлаар 1,678,139 зээлдэгчийн 2.0 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зураг 3 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлийн үлдэгдлийн 90.5 хувийг буюу 1,821.9 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 2.5 хувийг буюу 50.0 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 7.0 хувийг буюу 140.2 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /хувиар/



Нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 2.4, 3.3 пунктээр буурсан бол хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.7 пунктээр өссөн байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 190.2 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 60.3%-д буюу 114.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.


Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 68.1% буюу 2.0 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 11.0% буюу 331.4 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 67.2% буюу 1.6 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 11.5% буюу 266.7 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Олгосон зээлийн 91.5% буюу 2.8 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 8.5% буюу 257.5 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 91.3% буюу 2.1 их наяд төгрөг нь иргэдээс, 8.7% нь буюу 202.8 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	21,745.7	0.7%	19,625.4	0.8%	23,796.9	1.2%
2.	Уул уурхай, олборлолт	50,284.6	1.7%	36,094.0	1.6%	52,996.5	2.6%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	36,379.1	1.2%	31,141.3	1.3%	29,710.3	1.5%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	4,340.9	0.1%	3,830.6	0.2%	2,734.7	0.1%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,022.7	0.1%	2,199.4	0.1%	2,586.7	0.1%
6.	Барилга	160,472.4	5.3%	150,090.4	6.5%	177,863.0	8.8%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	331,423.1	11.0%	266,681.7	11.5%	266,518.4	13.2%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	79,876.6	2.6%	35,988.5	1.5%	82,206.3	4.1%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	30,010.4	1.0%	20,301.4	0.9%	24,554.2	1.2%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	71,100.5	2.4%	60,116.3	2.6%	82,595.3	4.1%
11.	Мэдээлэл холбоо	13,236.6	0.4%	10,468.6	0.4%	9,247.4	0.5%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	43,631.7	1.4%	29,246.2	1.3%	34,750.0	1.7%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	15,553.5	0.5%	12,972.9	0.6%	15,143.0	0.8%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6,169.1	0.2%	3,696.4	0.2%	5,174.3	0.3%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	19,149.9	0.6%	15,483.9	0.7%	16,484.8	0.8%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,824.7	0.1%	1,815.3	0.1%	1,276.0	0.1%
17.	Боловсрол	12,745.2	0.4%	12,954.3	0.6%	9,865.5	0.5%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	60,661.4	2.0%	49,960.3	2.1%	40,608.4	2.0%
19.	Бусад	2,054,931.4	68.1%	1,564,302.9	67.2%	1,134,061.9	56.4%
<i>Иргэнд олгосон зээл</i>		<i>2,758,077.3</i>	<i>91.5%</i>	<i>2,124,172.2</i>	<i>91.3%</i>	<i>1,759,914.0</i>	<i>87.5%</i>
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		<i>257,482.2</i>	<i>8.5%</i>	<i>202,797.8</i>	<i>8.7%</i>	<i>252,259.7</i>	<i>12.5%</i>
НИЙТ		3,015,559.5	100.0%	2,326,969.9	100.0%	2,012,173.7	100.0%

Тайлант улиралд олгосон 3.0 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1-2.5 жилийн хугацаатай олгосон зээл нийт зээлийн 7.6 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 20.5 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 5 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн ангиллаас харахад иргэнд олгосон зээлийн 66.6 хувийг хэрэглээнд, үүний 16.9 хувийг автомашинд зориулсан зээл бүрдүүлж байна. Хуулийн этгээдэд олгосон зээлийн 7.4 хувийг бизнесийн зээл бүрдүүлж байна.

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	2,758.1	91.5%	2,124.2	91.3%	1,759.9	87.5%
Хэрэглээнд зориулсан зээл	2,008.4	66.6%	1,492.4	64.1%	1,101.0	54.7%
Үүнээс: Автомашинд зориулсан зээл	509.9	16.9%	347.1	14.9%	422.4	21.0%
Бизнесд зориулсан зээл	442.1	14.7%	381.4	16.4%	386.5	19.2%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	117.3	3.9%	92.0	4.0%	141.6	7.0%
Бусад зээл	190.2	6.3%	158.4	6.8%	130.8	6.5%
Хуулийн этгээдэд олгосон зээл	257.5	8.5%	202.8	8.7%	252.3	12.5%
Бизнесийн зээл	224.2	7.4%	174.9	7.5%	207.5	10.3%
Автомашинны зээл	7.5	0.2%	9.2	0.4%	12.0	0.6%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	9.0	0.3%	6.6	0.3%	7.5	0.4%
Бусад зээл	16.7	0.6%	12.1	0.5%	25.3	1.3%
НИЙТ	3,015.6	100.0%	2,327.0	100.0%	2,012.2	100.0%

Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2021 оны жилийн эцсийн байдлаар 28 ББСБ үзүүлж байгаа бөгөөд үүний 11 ББСБ нь зөвхөн онлайн зээлийн үйлчилгээ санал болгож байгаа бол 17 ББСБ нь уламжлалт болон дэвшилтэт технологи хослуулан зээл олгож байна. Мөн 8 ББСБ онлайн зээл олгохоор туршилтын аппликэйшн гаргасан байна.

Хүснэгт 19 Уламжлалт болон финтек зээлийн тоо мэдээ

	Зээлийн дүн	Эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Эзлэх хувь	Харилцагчдын тоо	Эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	1,704,136,743.6	84.7%	329,023	19.6%	381,081	7.9%	5,179.4
Финтек	308,036,950.3	15.3%	1,349,116	80.4%	4,439,543	92.1%	228.3
Нийт	2,012,173,693.9		1,678,139		4,820,624		1,199.1

2021 оны жилийн эцсийн байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшнээр 1.3 сая зээлдэгчийн 308.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 228.3 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	App нэр
	Ашид капитал	Simple
2	Соно финтек	Sono mongolia
3	Лэндмн	lendmn
4	Очир ундраа ОМЗ	Oray
5	Ардкредит	ard app
6	Нөмөр кредит	numur
7	Омни капитал	Moni dijital
8	Мобифинанс	monpay
9	Сэндли	Sendly
10	Централ капитал	kmobi
11	Бизнес-Инвест девелопмент	БИД
12	Жи Эс Би Капитал	GSB capital
13	Хатан суудал инвест	zeely
14	Эм Пи Эс Си	Toki
15	Говьфинанс	Cash One
16	Таван богд финанс	PayOn.mn
17	Зээл Эм Эн платформ	zeel.mn
18	Нэт капитал финанс корпораци	Netapp MN
19	Грийн финтек	t finance
20	Тус финтек	TUS fintech
21	Нанокапитал	Nano capital
22	Монголиа импакт финанс	qmoni
23	Хас хаан	Хас Хаан
24	Инвекор хэтэвч	pocket.mn
25	Смарткапитал фонд	mycredit.mn
26	Фин экспресс	FinEx.mn
27	Өсөх ундарга финанс	Ufinance
28	Солонго капитал	100k.mn
30	Гурван зуун жар файнанс	Minu pay
31	Гэрэлфинанс	Gerel
32	Микрокредит	Micro Credit
33	Начин заан финанс	Naizly.mn
34	Нэйшнл кредит юнион	tenlend
35	Сэнд эм эн	sendmn
36	Энт кредит инвестмент	Ent credit
37	Эс ай си эй финанс	SicaFinance
Нийт		

Мөн финтек буюу онлайн зээлийн үйлчилгээг зохицуулах эрх зүйн орчин тодорхойгүй байгаагаас дараах

компаниуд аппликэйшнүүдээр дамжуулан зээл олгож байна.

Хүснэгт 21 Зээл олгож буй аппликэйшнүүд

Зээл олгодог app	
1	Duulekh
2	Easyloan MN
4	esu finance
5	gerege
8	Hleasing
9	pass.mn
10	Qpay Wallet
11	Rain fintech
12	Unlock finance
14	Momo land
15	Lite+

“Грэйп сити” ХХК-ийн хөгжүүлсэн Мост мони аппликэйшнд холбогдсон 15 ББСБ тус аппликэйшнд байдаг үйлчилгээнүүдийг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлж байгаа эсэхийг тодруулах шаардлагатай байна.

Хүснэгт 22 Мост мони-д холбогдсон ББСБ-ууд

Мост монид холбогдсон ББСБ-ууд	
1	“Нэт капитал финанс корпораци ББСБ” ХХК
2	“Ардкредит ББСБ” ХХК
3	“Инвестос ББСБ” ХХК
4	“Химурга ББСБ” ХХК
5	“Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК
6	“Магнапрофит ББСБ” ХХК
7	“Мобифинанс ББСБ” ХХК
8	“Бизнес-Инвест Девелопмент ББСБ” ХХК
9	“Улз финанс ББСБ” ХХК
10	“Экспресс финанс сервис ББСБ” ХХК
11	“Бид Хасбаян-Өлзийт ББСБ” ХХК
12	“Тэлмэн хас ББСБ” ХХК
13	“Гэрэл кредит ББСБ” ХХК
14	“Эрхэт зоос ББСБ” ХХК
15	“Тайкун финанс ББСБ” ХХК

Бусад хөрөнгө

2021 оны жилийн эцсийн байдлаарх 243.1 тэрбум төгрөгийн бусад хөрөнгийн үлдэгдлийн 42.6% буюу 103.6 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 41.0% буюу 99.8 тэрбум төгрөг нь дансны цэвэр авлага, 16.3% буюу 39.7 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 23 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	243,124.1	123,806.6	178,270.6	64,853.5	115.8	238,478.0	4,646.1	38,058.3	27,043.9
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	103,638.2	40,859.6	82,067.0	21,571.2	-	102,264.8	1,373.5	4,886.5	14,731.4
-Үнэт цаасны	491.3	489.8	396.3	95.1	-	96.6	394.7	29.0	1.5
-Зээлийн	100,808.5	38,346.9	80,480.4	20,328.2	-	99,838.1	970.5	4,228.6	14,628.2
-Факторингийн	265.5	215.9	51.4	214.1	-	265.5	-	-	-
-Бусад	2,072.8	1,807.0	1,138.9	933.8	-	2,064.6	8.2	628.9	101.7
Авлага /цэврээр/	99,776.4	70,032.6	66,792.8	32,983.6	6.3	97,529.9	2,246.5	27,667.7	7,499.2
Нийт авлага	102,461.1	72,060.0	68,031.2	34,429.9	6.3	100,195.3	2,265.8	27,847.5	8,212.2
Хэвийн	98,560.1	69,864.2	65,611.4	32,948.8	2.8	96,324.1	2,236.1	27,653.2	7,378.7
Анхаарал хандуулах	520.8	20.4	497.7	23.1	3.5	511.1	9.7	9.6	64.5
Чанаргүй:	3,380.2	2,175.5	1,922.2	1,458.0	-	3,360.1	20.1	184.7	768.9
-Хэвийн бус	107.5	18.9	93.8	13.8	-	106.5	1.0	5.6	76.7
-Эргэлзээтэй	13.2	9.2	5.2	8.0	-	12.2	1.1	2.3	3.3
-Муу	3,259.5	2,147.4	1,823.2	1,436.3	-	3,241.4	18.0	176.8	688.9
Нийт авлага (валютын)	80,555.1	50,991.5	46,210.9	34,344.1	6.3	78,289.2	2,265.8	27,847.2	7,841.9
Нийт авлага (төгрөгийн)	21,906.1	21,068.6	21,820.3	85.8	-	21,906.1	-	0.3	370.2
(Авлагын эрсдэлийн сан)	2,684.7	2,027.4	1,238.4	1,446.3	-	2,665.4	19.3	179.8	713.0
Бусад актив	39,709.5	12,914.4	29,410.7	10,298.8	109.5	38,683.4	1,026.1	5,504.1	4,813.2

Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2021 оны жилийн эцсийн байдлаар 119.5 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 26.0 тэрбум төгрөгийн элэгдлийг хуримтлуулж бүртгэсэн байна.

Хүснэгт 24 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	119.5	56.5	75.0	44.5	0.5	116.5	3.0	10.5	11.7
Барилга байгууламж	45.2	27.2	20.7	24.5	0.1	44.4	0.9	2.3	1.9
Техник хэрэгсэл	41.2	12.7	33.6	7.6	0.1	39.6	1.7	1.8	3.6
Тавилга эд хогшил	13.9	6.9	10.8	3.2	0.2	13.6	0.3	2.6	3.1
Дуусаагүй барилга	4.7	2.2	3.2	1.4	-	4.7	-	0.1	0.3
Биет бус хөрөнгө	14.3	7.6	6.7	7.7	0.2	14.2	0.1	3.7	2.8
(Хуримтлагдсан элэгдэл)	26.0	11.9	19.2	6.7	0.1	25.1	0.9	2.9	3.6
Барилга байгууламжийн	4.7	3.1	2.0	2.7	0.0	4.6	0.1	0.7	0.1
Техник хэрэгслийн	15.0	5.6	12.2	2.9	0.0	14.4	0.6	0.8	1.9
Тавилга эд хогшлын	6.2	3.1	5.0	1.2	0.1	6.0	0.2	1.3	1.6

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 49.6 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт, 50.4 хувийг өр төлбөрийн өсөлт бүрдүүлж байна. ББСБ-ууд ихэвчлэн өөрийн хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэг онцлогоос үүдэн пассивын өсөлтийн дийлэнх хувийг өөрийн хөрөнгө тэр дундаа хувьцаат капиталын өсөлт бүрдүүлдэг байсан. Харин тайлант хугацаанд буюу 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт ББСБ-уудын 26.0% буюу 139 ББСБ-ын дотоод, гадаад банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрөөс татан төвлөрүүлсэн зээл болон итгэлцэл, нээлттэй болон хаалттай хүрээнд гаргасан өрийн бичгийн үлдэгдлийн дүн нийт пассивийн өсөлтийн 50.4 хувийг бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 25 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Пассивын үзүүлэлтүүд	2020.IV	Нийт дүнд	2021.IV	Нийт дүнд	Өөрчлөлт	
	дүн	ЭЗЛЭХ ХУВЬ	дүн	ЭЗЛЭХ ХУВЬ	дүн	хувь
Өр төлбөр	556,222.9	27.7%	910,808.8	33.6%	354,586.0	63.7%
Санхүүгийн эх үүсвэр	146,891.9	7.3%	246,887.0	9.1%	99,995.1	68.1%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	171,159.7	8.5%	282,915.0	10.4%	111,755.3	65.3%
Бусад эх үүсвэр	43,150.5	2.2%	54,361.7	2.0%	11,211.2	26.0%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	62,510.8	3.1%	149,772.8	5.5%	87,261.9	139.6%
Төслийн зээлийн санхүүжилт	20,766.9	1.0%	19,884.5	0.7%	(882.4)	-4.2%
Бусад өр төлбөр	111,743.0	5.6%	156,987.9	5.8%	45,244.9	40.5%
Эздийн өмч	1,450,668.6	72.3%	1,799,140.8	66.4%	348,472.2	24.0%
Хувьцаат капитал	1,017,715.4	50.7%	1,114,075.1	41.1%	96,359.7	9.5%
Бусад өмч	32,866.3	1.6%	50,593.2	1.9%	17,727.0	53.9%
Сангууд	1,128.4	0.1%	973.3	0.0%	(155.1)	-13.7%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	398,121.9	19.8%	563,339.2	20.8%	165,217.3	41.5%
Хоёрдогч өглөг	836.6	0.0%	70,160.0	2.6%	69,323.4	8286.8%
Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	2,006,891.4	100.0%	2,709,949.6	100.0%	703,058.2	35.0%

Сүүлийн 5 жилийн пассивын үзүүлэлтийг харвал салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2017 оны мөн үед 595.4 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 1.9 дахин өсөж 1.1 их наяд төгрөгт, өр төлбөрийн хувьд 4.3 дахин өсөж 910.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Зураг 6 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Санхүүгийн эх үүсвэр

2021 оны жилийн эцсийн байдлаар итгэлцлийн үйлчилгээний өглөг өмнөх оны мөн үеэс 68.1% буюу 99.9 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 49 ББСБ-аас 44 ББСБ 5,093 итгэмжлэгчээс 246.9 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Зураг 7 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/



Улаанбаатар хотын 43 ББСБ 5,089 итгэмжлэгчээс 244.9 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 4 итгэмжлэгчээс 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 26 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	246.9	120.8	126.1	244.9	2.0	79.1	167.8	65.8
-Төгрөгөөр	221.3	112.7	108.7	244.9	2.0	79.1	142.2	65.8
-Валютаар	25.6	8.1	17.4	219.3	2.0	70.9	(45.3)	60.5
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	49	35	14	48	1	4	45	5
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	44	32	12	43	1	4	40	5
Нийт итгэмжлэгчдийн тоо	5,093	2,584	2,509	5,089	4	285	4,808	254

Хамгийн өндөр дүнгээр буюу 52.3 тэрбум төгрөгийг 144 итгэмжлэгчээс татан төвлөрүүлсэн бол хамгийн олон буюу 2,003 итгэмжлэгчээс 704.7 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

2021 оны жилийн эцсийн байдлаар 94 ББСБ дотоод, гадаадын банк болон санхүүгийн байгууллагаас 282.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 27 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	282.9		181.6	161.9	121.0	281.2	1.7	53.7	229.2	65.0
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл	110.1	38.9%	77.8	74.2	35.9	109.8	0.3	22.8	87.3	20.4
Урт хугацаат зээл	172.9	61.1%	103.8	87.8	85.1	171.4	1.4	30.9	142.0	44.7
Валотын төрлөөр:										
Төгрөгөөр	201.8	71.3%	129.8	104.8	96.9	200.0	1.7	34.8	167.0	32.4
Валютаар	81.2	28.7%	51.7	57.1	24.0	81.2	-	18.9	62.3	32.7
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	209.0	73.9%	133.3	112.1	96.9	207.3	1.7	38.2	170.8	35.8
Зээл /төгрөгөөр/	201.8	71.3%	129.8	104.8	96.9	200.0	1.7	34.8	167.0	32.4
Зээл /валютаар/	7.2	2.6%	3.5	7.2	-	7.2	-	3.5	3.8	3.5
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	73.9	26.1%	48.3	49.9	24.0	73.9	-	15.4	58.5	29.2

Бусад эх үүсвэр

2021 оны жилийн эцсийн байдлаар 10 ББСБ 14.8 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, 1 ББСБ 316.8 сая төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй, 8 ББСБ 39.2 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний

өглөгтэй, 1 ББСБ 112.5 мянган төгрөгийн гадаад валютын арилжааны эх үүсвэрийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 28 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	Дүн	Эзлэх хувь	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Нийт	54,361.7	100.0%	42,200.9	6,936.1	47,425.5	54,361.7	-	150.2	54,211.5	1,174.1
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	14,809.95	27.2%	8,852.0	5,525.8	9,284.2	14,810.0	-	150.2	14,659.7	1,174.1
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	316.84	0.6%	316.8	-	316.8	316.8	-	-	316.8	-
Факторингийн үйлчилгээний өглөг	39,234.78	72.2%	33,032.1	1,410.3	37,824.5	39,234.8	-	-	39,234.8	-

Зураг 8 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/

Бусад эх үүсвэр	2017-IV	2018-IV	2019-IV	2020-IV	2021-IV
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	3.7	4.0	4.0	6.0	14.8
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3.0	3.5	4.4	5.7	0.3
Факторингийн үйлчилгээний өглөг	-	8.1	24.9	31.5	39.2
Нийт	6.7	15.7	33.3	43.2	54.4

Өмнөх оны мөн үеэс төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 94.4 хувиар буурсан бол мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 2.5 дахин, факторингийн үйлчилгээний өглөг 1.2 дахин тус тус өссөн байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 165 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам” батлагдсантай холбогдуулан ББСБ-ууд хаалттай хүрээнд өрийн бичиг шинээр гаргах, сунгахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах шаардлага үүссэн.


2021 оны жилийн эцсийн байдлаар 21 ББСБ-ын өрийн бичиг гаргах асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 29 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
		149,772.8	98,298.8	113,809.7	35,963.1	149,719.6	53.2	35,125.8	114,646.9
Төгрөгөөр	139,442.3	93,199.5	103,479.3	35,963.1	139,389.1	53.2	35,125.8	104,316.5	27,272.0
Валютаар	10,330.5	5,099.4	10,330.5	-	10,330.5	-	-	10,330.5	-

2021 оны жилийн эцсийн байдлаар 40 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 1,274 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 149.8 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Зураг 9 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Өрийн бичгийн үлдэгдэл 2017 оны мөн үеэс 21.7 дахин өсөж 149.8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 14.4% байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 7.5 пунктээр буурч 6.9%-д хүрсэн байна.

Тайлант хугацаанд 3 ББСБ олон нийтэд өрийн бичиг санал болгосон байна. Эдгээр 3 ББСБ-ын хаалттай болон нээлттэй санал болгосон өрийн бичгийн үлдэгдэл нь нийт өрийн бичгийн үлдэгдлийн 17.4% буюу 26.0 тэрбум төгрөгийг, харилцагчдын 882 нь буюу 69.2 хувийг бүрдүүлж байна.

Төслийн зээлийн санхүүжилт

2020 оны жилийн эцсийн байдлаар төсөл хөтөлбөрөөс 25 ББСБ 20.8 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар төсөл хөтөлбөрөөс 18 ББСБ 19.9 тэрбум төгрөгийг төслийн санхүүжилтээр татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 30 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн 19,884.5	Нийт дүнд эзлэх хувь	Итгэлцэл 13,285.1	Уламжлалт 15,584.5	Финтек 4,300.0	УБ 17,600.8	ХОН 2,283.7	ХК -	ХХК 19,884.5	ГХО 8,570.8
Хугацаагаар										
Богино хугацаат	2,321.4	11.7%	500.0	2,321.4	-	2,036.6	284.8	-	2,321.4	821.0
Урт хугацаат	17,563.1	88.3%	12,785.1	13,263.1	4,300.0	15,564.2	1,998.9	-	17,563.1	7,749.8
Төрлөөр										
Засгийн газрын	-	-	-	-	-	-	-	-	-	-
Гадаадын	8,252.2	41.5%	7,749.8	8,252.2	-	8,252.2	-	-	8,252.2	7,749.8
Дотоодын	8,849.0	44.5%	4,505.0	4,549.0	4,300.0	6,567.3	2,281.7	-	8,849.0	741.0
Бусад	2,783.3	14.0%	1,030.3	2,783.3	-	2,781.3	2.0	-	2,783.3	80.0
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	16,668.3	83.8%	10,068.9	12,368.3	4,300.0	14,384.6	2,283.7	-	16,668.3	5,354.6
Валютаар	3,216.2	16.2%	3,216.2	3,216.2	-	3,216.2	-	-	3,216.2	3,216.2

Бусад өр төлбөр

2021 оны жилийн эцсийн байдлаар 502 ББСБ 157.0 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Үүний 15.8% буюу 24.9 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг, 83.9% буюу 131.8 тэрбум төгрөг нь бусад пассив, 0.2% буюу 360.6 сая төгрөг нь санхүүгийн үүсмэл хэрэгсэл (дериватив)-ийн өглөгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 31 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	156,987.9	102,696.8	106,081.8	50,906.0	187.4	155,881.5	1,106.4	36,491.4	120,496.5	30,319.3
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	24,865.8	17,003.9	13,538.6	11,327.2	-	24,840.8	25.0	7,574.3	17,291.5	6,890.4
Ангиллаар										
Зээлийн	11,612.7	4,329.2	6,972.4	4,640.3	-	11,588.1	24.6	1,331.7	10,280.9	1,830.3
Үнэт цаасны	2,097.9	1,870.3	823.3	1,274.6	-	2,097.9	-	670.8	1,427.1	642.0
Бусад	11,155.2	10,804.4	5,743.0	5,412.2	-	11,154.8	0.4	5,571.7	5,583.5	4,418.1
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	23,144.4	15,784.4	12,533.8	10,610.6	-	23,119.4	25.0	7,184.3	15,960.1	6,427.0
Валютаар	1,721.4	1,219.5	1,004.8	716.6	-	1,721.4	-	390.0	1,331.4	463.4
Бусад пассив	131,761.5	85,332.3	92,182.6	39,578.9	187.4	130,680.0	1,081.5	28,917.1	102,844.4	23,428.9
Деривативийн өглөг	360.6	360.6	360.6	-	-	360.6	-	-	360.6	-

Хувь нийлүүлсэн хөрөнгө


Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.5% буюу 96.3 тэрбум төгрөгөөр өсөж 1.1 их наяд төгрөгт хүрсэн ба энэ нь нийт пассивын 41.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 32 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	1,114,075.1	242,107.4	933,380.8	180,694.3	13,488.3	1,074,041.9	40,033.2	27,342.6	1,086,732.5	91,656.1
Энгийн хувьцаа	1,115,873.3	244,625.3	932,841.5	183,031.8	13,488.3	1,075,882.4	39,990.9	29,683.7	1,086,189.6	91,538.7
Давуу эрхтэй хувьцаа	749.7	30.0	749.7	-	-	707.4	42.3	-	749.7	121.0
Халаасны хувьцаа	2,548.0	2,548.0	210.4	2,337.5	-	2,548.0	-	2,341.1	206.8	3.6

2021 оны жилийн эцсийн байдлаар 534 ББСБ-ын 1.1 их наяд төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 749.7 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 2.5 тэрбум төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад халаасны хувьцааны дүн 2.0 дахин өссөн байна.

Зураг 10 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



1.9 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 222 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 70.6% буюу 786.5 тэрбум төгрөг байна. Харин 1.9 тэрбум төгрөг хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 312 ББСБ-ын 327.6 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 29.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 33 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	279.0	27	25.0%	5.1%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	376.8	130	33.8%	24.3%	2.5	1	3.2	1	-	-
1.9-2.5 тэрбум	130.7	65	11.7%	12.2%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	290.4	200	26.1%	37.5%	1.4	1	2.8	2	1.4	1
0.6-1.4 тэрбум	16.3	19	1.5%	3.6%	3.9	5	7.7	9	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	21.0	93	1.9%	17.4%	2.2	6	10.4	54	8.4	33
НИЙТ	1,114.1	534	100.0%	100.0%	15.6	14	24.1	66	13.5	38

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 53.9 хувиар өсөж 50.6 тэрбум төгрөгт, сангууд 13.7 хувиар буурч 973.3 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 34 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/


	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Бусад өмч	50,593.2	39,513.5	29,487.9	21,105.4	257.9	50,245.8	347.5	37,381.6	13,211.7	18,582.4
Нэмж төлөгдсөн капитал	34,254.8	26,455.8	26,155.3	8,099.5	228.1	34,176.9	77.9	25,771.4	8,483.4	18,577.5
Дахин үнэлгээний нэмэгдэл	14,154.9	12,316.4	1,890.4	12,264.5	-	14,019.6	135.3	11,552.8	2,602.1	4.9
Хандивын капитал	2,183.5	741.3	1,442.2	741.3	29.7	2,049.3	134.2	57.3	2,126.2	-
Сангууд	973.3	18.9	969.2	4.1	-	268.0	705.3	-	973.3	0.6
Нөөцийн сан	520.8	12.5	520.8	-	-	18.9	501.9	-	520.8	-
Нийгмийн хөгжлийн сан	452.4	6.4	448.4	4.1	-	249.1	203.3	-	452.4	0.6

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 41.5% буюу 165.2 тэрбум төгрөгөөр өсөж 563.3 тэрбум төгрөгт хүрчээ.

2021 оны жилийн эцсийн байдлаар 440 ББСБ 213.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 10 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 84 ББСБ 3.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 35 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/




Хоёрдогч өглөг

2021 оны жилийн эцсийн байдлаар салбарын нийт пассивын хамгийн өндөр өсөлтийг хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн дүн бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үеэс 83.9 дахин өсөж 9 ББСБ 70.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2021 онд нийт 6 ББСБ хоёрдогч өглөг татан төвлөрүүлэх зөвшөөрөл авсан байна.

2017 оны мөн үед 709.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар хоёрдогч өглөгийн хэмжээ 99.3 дахин өсөж 70.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Хүснэгт 36 Хоёрдогч өглөгийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар /сая төгрөгөөр/



Ашигт ажиллагаа

2021 оны жилийн эцсийн байдлаар ББСБ-ууд 521.3 тэрбум төгрөгийн орлого олж, 311.3 тэрбум төгрөгийн зардал гаргаж 21.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс орлогын хэмжээ 27.5% буюу 112.5 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 22.6% буюу 57.3 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 35.7% буюу 55.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 11 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн бус орлого 40.0% буюу 24.9 тэрбум төгрөгөөр өсжээ. Энэхүү өсөлтийн 54.5 хувийг санхүүгийн үйлчилгээний орлогын бусад орлогын өсөлт, 62.4 хувийг үйлчилгээний хураамж шимтгэлийн орлогын өсөлт бүрдүүлж байна.

Хүснэгт 37 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, мянган төгрөгөөр/

ОРЛОГО	2020.IV	2021.IV	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	337,936,790.3	421,707,391.2	80.9%	83,770,600.8	24.8%
Хүүгийн бус орлого	62,174,095.9	87,036,660.6	16.7%	24,862,564.7	40.0%
- Санхүүгийн үйлчилгээний орлого	45,246,559.6	72,973,722.9	14.0%	27,727,163.3	61.3%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	67,748.1	15,634.4	0.0%	-52,113.6	-76.9%
- Мөнгөн гүйвүүлгын орлого	1,526,204.5	2,616,496.7	0.5%	1,090,292.2	71.4%
- Картын үйлчилгээний орлого	2,433,099.9	4,330.2	0.0%	-2,428,769.7	-99.8%
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	110,938.9	149,555.2	0.0%	38,616.2	34.8%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	31,759,535.8	47,280,655.5	9.1%	15,521,119.7	48.9%
- Бусад	9,349,032.3	22,907,050.9	4.4%	13,558,018.6	145.0%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	8,542,087.5	12,452,378.7	2.4%	3,910,291.2	45.8%
Ердийн бус орлого	119,218.9	68,203.8	0.0%	(51,015.1)	-42.8%
НИЙТ ОРЛОГО	408,772,192.5	521,264,634.2	100.0%	112,492,441.7	27.5%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	42,561,185.1	47,993,564.7	15.4%	5,432,379.6	12.8%
Хүүгийн бус зардал	148,023,093.2	193,491,809.2	62.2%	45,468,716.0	30.7%
Болзошгүй эрсдэлийн зардал	43,680,310.0	37,303,481.2	12.0%	(6,376,828.8)	-14.6%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	4,262,842.3	6,712,666.0	2.2%	2,449,823.7	57.5%
Орлогын албан татварын зардал	15,431,648.3	25,711,307.0	8.3%	10,279,658.7	66.6%
Ердийн бус зардал	14,325.2	46,669.7	-	32,344.5	225.8%
НИЙТ ЗАРЛАГА	253,973,404.2	311,259,497.8	100.0%	57,286,093.6	22.6%
АШИГ					
ЦЭВЭР АШИГ	154,798,788.4	210,005,136.4	100.0%	55,206,348.1	35.7%

Санхүүгийн үйлчилгээний орлогын хувьд өмнөх оны мөн үеэс бусад орлого 61.3 хувиар өсөж хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бол итгэлцлийн үйлчилгээний орлого 76.9 хувиар, картын үйлчилгээний орлого 99.8 хувиар тус тус буурсан үзүүлэлт гарчээ.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс ердийн бус зардал 3.3 дахин өсөж хамгийн өндөр өсөлт үзүүлсэн бол орлогын албан татварын зардал 66.6% буюу 10.3 тэрбум төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны зардал 57.5% буюу 2.4 тэрбум төгрөгөөр, хүүгийн бус зардал

30.7% буюу 45.5 тэрбум төгрөгөөр, хүүгийн зардал 12.8% буюу 5.4 тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Болзошгүй эрсдэлийн зардал өмнөх оны мөн үеэс 6.4 тэрбум төгрөг буюу 14.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 38 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хүүгийн орлого	421,707.4	219,582.6	281,571.9	140,135.5	-	412,848.0	8,859.3	41,535.3	59,328.8
Хүүгийн бус орлого	87,036.7	50,610.3	47,715.1	39,321.6	901.8	86,156.6	880.0	29,000.7	16,103.3
- Санхүүгийн үйлчилгээний орлого	72,973.7	47,553.1	36,138.0	36,835.7	0.2	72,104.4	869.3	28,496.7	13,169.7
<i>Итгэлцлийн үйлчилгээний орлого</i>	15.6	15.6	-	15.6	-	15.6	-	2.6	-
<i>Мөнгөн гуйвуулгын орлого</i>	2,616.5	295.1	2,356.0	260.5	-	2,616.5	-	-	-
<i>Картын үйлчилгээний орлого</i>	4.3	-	4.3	-	-	4.3	-	-	-
<i>Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого</i>	149.6	149.6	-	149.6	-	149.6	-	149.6	-
<i>Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого</i>	47,280.7	37,986.1	17,902.4	29,378.2	-	46,566.5	714.2	23,048.9	9,151.0
<i>Бусад</i>	22,907.1	9,106.8	15,875.3	7,031.7	0.2	22,751.9	155.1	5,295.7	4,018.7
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12,452.4	7,978.3	9,583.0	2,869.4	1.8	12,032.0	420.4	2,953.9	2,112.8
Ердийн бус орлого	68.2	2.8	68.2	-	1.0	61.4	6.8	-	-
НИЙТ ОРЛОГО	521,264.6	278,174.0	338,938.2	182,326.5	904.7	511,098.0	10,166.6	73,489.9	77,544.8
ЗАРДАЛ									
Хүүгийн зардал	47,993.6	32,620.5	24,593.8	23,399.8	-	47,684.5	309.0	7,685.4	8,658.7
Хүүгийн бус зардал	193,491.8	106,423.4	107,851.9	85,639.9	814.3	189,721.5	3,770.3	31,195.1	29,727.7
Болзошгүй эрсдэлийн зардал	37,303.5	16,422.6	26,830.7	10,472.8	-	36,782.8	520.7	3,851.4	2,842.3
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6,712.7	3,503.8	4,746.5	1,966.2	0.7	6,630.8	81.9	856.5	643.9
Орлогын албан татварын зардал	25,711.3	15,390.5	18,912.6	6,798.7	4.5	25,304.9	406.4	5,399.2	5,483.6
Ердийн бус зардал	46.7	0.2	46.7	-	-	43.4	3.3	-	2.3
НИЙТ ЗАРЛАГА	311,259.5	174,361.1	182,982.1	128,277.4	819.5	306,167.9	5,091.6	48,987.7	47,358.4
АШИГ									
ЦЭВЭР ОРЛОГО	210,005.1	103,812.9	155,956.0	54,049.1	85.1	204,930.1	5,075.0	24,502.2	30,186.4

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 534 ББСБ-ын 86.3% буюу 461 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 13.7% нь буюу 73 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 61 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 10 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ, 6 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 39 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Итгэлцэл /49 ББСБ/		Итгэлцэл, ГВА-аас бусад /447 ББСБ/		ЗГВА /38 ББСБ/		Нийт /534 ББСБ/		
		√	X	√	X	√	X	√	X	
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	49	-	443	4	38	-	530	4	
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	49	-	443	4	38	-	530	4	
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	49	-	445	2	38	-	532	2	
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	46	3	431	16	37	1	514	20	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+ишүү,- дутуу)	48	1	426	21	37	1	511	23	
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	49	-	437	10	XXX		524	10	
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	49	-	447	-			534	-	
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	49	-	446	1			533	1	
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	49	-	445	2			532	2	
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	49	-	447	-			534	-	
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	49	-	447	-			534	-	
12.	Монголын хөрөнгийн биржийн “II”, “III” ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	49	-	446	1			533	1	
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	49	-	447	-			534	-	
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа	49	-	446	1			533	1	
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	47	2	438	9			523	11	
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	49	-	XXX				534	-	
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа	49	-	447	-			-	-	
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	48	1	437	10		37	1	522	12

Тайлбар: √ - ЗХШҮ хангасан ББСБ-ын тоо
X - ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг хамгийн олон буюу 23 ББСБ дутуу байгуулсан бол төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 20 ББСБ хангаагүй, үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 12 ББСБ хангаагүй, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 11 ББСБ хангаагүй буюу хамгийн их алдагдсан байна.

Дүгнэлт

2021 оны жилийн эцсийн байдлаар тайлан мэдээг ирүүлбэл зохих 534 ББСБ-аас 517 ББСБ жилийн эцсийн тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 15 ББСБ өмнөх үеийн, 2 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2021 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 21,793 хувьцаа эзэмшигчдийн 534 ББСБ, 331 салбар нэгж, 8 төлөөлөгчийн газар, 3,976 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.8 сая харилцагч, 1.7 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар салбарын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.0 хувиар, ашигт ажиллагаа 35.7 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа боловч нөгөө талдаа бусдаас эх үүсвэр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 74.3 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан өр төлбөрийн дүн 63.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ-ууд ББСБ-уудын өмнөх улирлын тайлангуудад пассивын өсөлтийн дийлэнх хувийг өөрийн хөрөнгө тэр дундаа хувьцаат капиталын өсөлт бүрдүүлдэг байсан. Харин тайлант хугацаанд буюу 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт ББСБ-уудын 26.0% буюу 139 ББСБ-ын дотоод, гадаад банк, санхүүгийн байгууллага, төсөл хөтөлбөрөөс татан төвлөрүүлсэн зээл болон итгэлцэл, нээлттэй болон хаалттай хүрээнд гаргасан өрийн бичгийн үлдэгдлийн дүн нийт пассивын өсөлтийн 50.4 хувийг бүрдүүлж байна. Иймд эдгээр томоохон ББСБ-уудын үйл ажиллагаанд тавигдах зайны болон газар дээрх хяналтыг сайжруулж, салбарт үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

ББСБ-уудын нэгтгэлийн танилцуулгыг боловсруулах явцад бусдаас итгэлцэл болон өрийн бичиг хэлбэрээр эх үүсвэр татсан ББСБ-уудын тухайн үйлчилгээний харилцагчдын тоо нь статистик мэдээлэл болон тухайн тайлангийн дэлгэрэнгүй хэсэгт бөглөсөн тоо мэдээнээс зөрөх, аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд “Зээл олголт эргэн төлөлт, зээлийн хүүгийн судалгааны тайлан”-г дутуу нөхсөнөөс үүдэн мэдээллийг дахин тодруулах шаардлага үүсэж байна. Мөн аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-уудын бүртгэлийг нэгдсэн бүртгэлд бүртгэх, заавал танилцуулга хийх шаардлагыг ББСБ-уудад тавих шаардлагатай байна.

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 20 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 27 ББСБ санхүүгийн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 14 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна. Нэр бүхий 13 ББСБ тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн байна

Сүүлийн үед санхүүгийн салбарт ихээр дэлгэрээд байгаа виртуал хөрөнгө нь /койн, токен.../ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд хамрагдах хувьцаа, үнэт цаас, төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий, мөнгөн хөрөнгөөр баталгаажуулаагүй, зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийн шинжийг агуулаагүй, компанийн хөрөнгө, хувьцаа хэлбэрээр баталгаажих боломжгүй тухай мэдэгдлийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос удаа дараа анхааруулсан.

Мөн Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т “тусгай зөвшөөрөлд зааснаас өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх”, мөн хуулийн 12.1.2-т “өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх”, мөн хуулийн 12.1.5-т “банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах”-ыг тус тус хориглосон байдаг.

Виртуал хөрөнгө буюу койн, токен зэрэг нь хуулиар зөвшөөрсөн хөрөнгө оруулалтын болон төлбөрийн хэрэгсэл биш тул хуулиар зохицуулагдаагүй койн токен

зэргийг зохицуулалттай этгээдүүдийн нэр дор гаргахгүй байх, үйл ажиллагаандаа ашиглахгүй байхыг ББСБ-уудад анхааруулж ажиллах шаардлагатай байна.

Цар тахалтай холбогдуулан эдийн засгийн байдал хүндэрч, иргэд аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа доголдсонтой холбогдуулан иргэдийг чанаргүй зээлийн ангилалд шилжүүлэхээс урьдчилан сэргийлж ББСБ-уудад мөрдөгдөж буй “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, үйлчлэлийн хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан. Өөрөөр хэлбэл, зээлийн хугацааг 60 хоног хүртэлх хугацаанд хэвийн ангилалд ангилах, зээлийн гэрээг 2 болон түүнээс дээш сунгасан тохиолдолд ангилал бууруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Үүний үр дүнд ББСБ-ууд шийдвэр гарснаас хойш тайлант улирал хүртэл хугацаанд нийт 426.6 мянган зээлдэгч 592.2 тэрбум төгрөгийн зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд 380 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 411.7 мянган зээлдэгчийн 452.7 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгасан байна.

Дээрх журмын үйлчлэлийн хугацаа 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дууссан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 998 дугаар тогтоолоор баталсан “[Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам](#)”-ыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллана.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР